



ХЭНТИЙ АЙМГИЙН
ЦЭНХЭРМАНДАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 06 сарын 10 өдөр

Дугаар А/68

Модот

Орон нутгийн хөгжлийн сангийн эрэмблэх
ажлын хэсэг томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйл, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар журмын 6 дугаар зүйлийн 6.1, 6.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажил, бараа, үйлчилгээг эрэмблэх ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай. Үүнд:

Дарга:	Ү.Ичинхорлоо	-	Засаг даргын тамгын газрын дарга
Нарийн бичгийн дарга	Г.Болор-Эрдэнэ	-	Санхүү албаны дарга
Гишүүд	С.Энхбаяр	-	Байгаль орчны хяналтын улсын байцаагч
	Д.Өсөхгэрэл	-	Мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээний хяналтын улсын байцаагч
	Д.Оюунбаяр	-	ИТХурал, соёл хариуцсан нягтлан бодогч
	С.Энхбямба	-	Ахмадын хорооны дарга
	Ш.Оюунчимэг	-	Хөдөө аж ахуйн тасгийн мэргэжилтэн

2.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлыг эрэмблэх, батлагдсан хөрөнгийг зөв зохистой зарцуулах, төсөл хөтөлбөрийг боловсруулах ажлыг хариуцлагатай хийхийг томилогдсон нийт бүрэлдэхүүнд үүрэг болгосугай.

3.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын төсөл хөтөлбөрт хяналт тавьж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч (Ү.Ичинхорлоо)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамж гарсантай холбогдуулан 2024 оны 03 дугаар сарын 28-ны өдрийн А/30 тоот захирамжийг хүчингүйд тооцоугай.

ЗАСАГ ДАРГА

А.МӨНХ-ОРГИЛ

